



ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧДОД ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ МЕХАНИЗМЫН ЗУРАГЛАЛ

Судалгааны тайлан

Судалгааны зорилго, зорилт:

Монгол Улсын хүн худалдаалах гэмт хэрэг, хохирогч хамгааллын тогтолцоо, үйлчилгээний одоогийн механизм болон бусад орны туршлагыг судлан өөрийн орны нөхцөл байдалд тохирсон санал, зөвлөмж боловсруулах

Зорилтууд:

1. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хохирогчдод туслалцаа, үйлчилгээ үзүүлэх тогтолцоо, механизмын өнөөгийн нөхцөл байдлыг судлах;
2. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлж буй одоогийн үйлчилгээний зураглалыг гаргах;
3. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төрийн байгууллага, ТББ-аас авч буй үйлчилгээний талаарх саналыг авч, тэднийг ХХГХ-т өртөхөд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох;
4. Хохирогчийг хамгааллын талаарх холбогдох хууль тогтоомж болон Үндэсний хөтөлбөрийн (2017-2021) хэрэгжилт, түүнд үүрэг хүлээсэн байгууллагуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлох;
5. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хохирогчид туслалцаа, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр бусад орны туршлагыг судлах, өөрийн улсад нэвтрүүлэх санал зөвлөмжийг томъёолох зэрэг юм.

Судалгааны тайлангийн бүтэц

БҮЛЭГ 1: ЕРӨНХИЙ ТОЙМ

БҮЛЭГ 2: СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

БҮЛЭГ 3: Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх ойлголт

БҮЛЭГ 4: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлсэн туслалцаа, үйлчилгээ

БҮЛЭГ 5: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх туслалцааны өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ

БҮЛЭГ 6: Хүн худалдаалахтай тэмцэж буй бусад улс орны туршлага

ДҮГНЭЛТ

ЗӨВЛӨМЖ

БҮЛЭГ 3: Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх ойлголт

1. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин
 1. Эрүүгийн хууль
 2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
 3. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль
 4. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль
2. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын Конвенцийн нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол буюу Палермогийн протокол
3. Хүн худалдаалах гэмт хэргийн тодорхойлолт
4. Хүн худалдаалах гэмт хэргийн төрөл, хэлбэр
5. Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчдод үзүүлэх туслалцаа, үйлчилгээ

БҮЛЭГ 4: Хүн худалдаалах гэмт хэргийн хохилогчдод үзүүлсэн туслалцаа, үйлчилгээ

1. Хохирогч тусламж, үйлчилгээнд хамрагдсан байдал
 - 1.Хохирогч өөрөө хандах
 - 2.Цагдаагийн байгууллага хохирогчийг илрүүлэх
 - 3.Хохирогчийн ар гэрийнхэн хандах
 - 4.Хохирогчийн найз нөхөд, танил тал нь хандах, хандуулах
 - 5.Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажилладаг төрийн, төрийн бус байгууллагууд хандуулах
 - 6.Хууль хяналтын байгууллагын ажилтнууд хандуулах

БҮЛЭГ 5: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх туслалцааны өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх туслалцаа, үйлчилгээ

1. Анхан шатны туслалцаа, үйлчилгээ

- ✓ Хохирогчийг илрүүлэх, тогтоох
- ✓ Эх оронд нь эгүүлэн авчрах үйлчилгээ
- ✓ Хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах байрны үйлчилгээ
- ✓ Хууль зүйн туслалцаа, өмгөөлөл
- ✓ Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ, үйлчилгээ
- ✓ Эрүүл мэндийн үйлчилгээ
- ✓ Тусгай хэрэгцээ, эдийн засгийн туслалцаа

2. Эргэн нийгэмшүүлэх туслалцаа, үйлчилгээ


- ✓ Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт
- ✓ Урт хугацааны нөхөн сэргээх гэр, ажлын байр


БҮЛЭГ 6: Хүн худалдаалахтай тэмцэж буй бусад улс орны туршлага

1. “4P”-ийн тогтолцоо
 - a) Урьдчилан сэргийлэх/Prevention
 - b) Хохирогч хамгаалалт/Protection
 - c) Ял шийтгэл оногдуулах/Prosecution
 - d) Хамтын ажиллагаа/Partnership
2. Бусад улс орны туршлага
 - a) Филиппин улс
 - b) Америкийн Нэгдсэн Улс
 - c) Бүгд Найрамдах Солонгос Улс
 - d) Бүгд Найрамдах Хятад Ард Улс

ДУГНЭЛТ

ЗӨВЛӨМЖ





**ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ
ТЭМЦЭХ ХУУЛЬЭРХЗҮЙ, БОДЛОГЫН
ОРЧИН**

**113-Р ЗҮЙЛ. ХҮН
ХУДАЛДАХ,
ХУДАЛДАН
АВАХ**

2002

Эрүүгийн хуулинд
өнх удаа хүн
худалдаалах гэмт
хэргийг тусгасан.

**ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨР**

2005

ЗГ-аас 2005-2011 Хүн
худалдаалах, хүүхэд
эмэгтэйчүүдийг
бэлгийн мөлжлөгийн
зорилгоор
ашиглахаас хамгаалах
Үндэсний
хөтөлбөрийг баталсан.

**113-Р ЗҮЙЛ. ХҮН
ХУДАЛДААЛАХ**

2008

ЭХ-ийн заалт
Палермогийн
Конвенцид нийцэж
өөрчлөгдсөн,
УДШ тайлбар
гарсан

**ПАЛЕРМОГИЙН
ПРОТОКОЛД
НЭГДЭЖ
ОРСОН**

2008

УИХ-аас соёрхон
баталсан

**ХОХИРОГЧИЙН
ХАМГААЛАХ
БАЙРНЫ
НИЙТЛЭГ
ҮЙЛЧИЛГЭЭНД
ТАВИХ НИЙТЛЭГ
ШААРДЛАГА**

2009

УСХ-ноос
хохилогчийн
хамгаалах байрны
стандартыг баталж,
улс даяар дагаж
мөрдөх болсон.

**"ХҮН
ХУДАЛДААЛАХТАЙ
ТЭМЦЭХ
АСУУДЛААР
ХАМТРАН
АЖИЛЛАХ"
ХЭЛЭЛЦЭЭР**

2010

БНХАУ-ын
Макаогийн Засаг
захиргааны онцгой
бүсийн Засгийн
газар хооронд
байгуулсан

**ХҮН
ХУДАЛДААЛТАЙ
ТЭМЦЭХ ТУХАЙ
ХУУЛЬ**

2011

УИХ-аас ХХГХ-тэй
тэмцэх тухай бие
даасан хуулийг
баталсан.

**ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ
ТЭМЦЭХ ХУУЛЬЭРХЗҮЙ, БОДЛОГЫН
ОРЧИН**

**ГЭРЧ
ХОХИРОГЧИЙГ
ХАМГААЛАХ
ХУУЛЬ**

2013

УИХ-аас гэрч
хохилогчийг
хамгаалах хуулийг
батлан гаргасан.

**ТАХАРЫН
АЛБАНЫ ТУХАЙ
ХУУЛЬ**

2013

Тахарын албаны хууль
батлагдаж, 2014 онд
Тахарын алба шинээр
байгуулагдсан.

**ХХГХ-ИЙН
ХОХИРОГЧИД
ҮЗҮҮЛЭХ
НИЙГМИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНД
ТАВИХ НИЙТЛЭГ
ШААРДЛАГА, MNS
6418:2013**

2013

УСХЗГ-аас
хохилогчид үзүүлэх
үйлчилгээний
стандартыг
баталсан

**ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ
ХАМГААЛАХ,
ТУСЛАЛЦАА
ҮЗҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨР**

2015

МУ-ын Засгийн
газраас 2016-2024
онд хэрэгжих
үндэсний
хөтөлбөрийг
баталсан.

**ТАХАРЫН АЛБА
ТАТАН БУУГДСАН**

2016

2016 оны 7 дугаар
сарын 27-ны өдрийн
Засгийн газрын 2016
оны 4 дүгээр
тогтоолоор татан
буугдсан.

**ХҮН
ХУДАЛДААЛАХТАЙ
ТЭМЦЭХ
ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨРМӨН**

2017

МУ-ын Засгийн
газраас 2017-2021
онд хэрэгжих
үндэсний
хөтөлбөрийг батлан
гаргасан.

**13.1 ХҮН
ХУДАЛДААЛАХ**

2017

ЭХ-ийн шинэчилсэн
найруулгаар
хуулийн заалт
шинэчлэгдсэн.

№	Журмын нэр	Үндэслэл	Батлагдсан хугацаа	Хэн баталсан
1	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5.3.2, 12.1.5, 12.2 дах хэсэг	2013 оны 11-р сарын 15 Дугаар А/91	Гадаад харилцааны сайдын тушаал, Журам батлах тухай
2	Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18-р зүйлийн 18.3 дахь хэсэг	2014 оны 10-р сарын 24 Дугаар А/356, А/182	Эрүүл мэндийн сайд Хууль зүйн сайд хамтарсан тушаал, Журам батлах тухай
3	Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12.1.3, 12.2 дах заалт	2015 оны 07-р сарын 09 Дугаар А/135	Хөдөлмөрийн сайдын тушаал, Журам шинэчлэн батлах тухай
4	Сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ		???	
5	Хууль зүйн туслалцаа		Батлагдаагүй.	

Хүн худалдаалах гэмтхэргийн
хохирогчийг тогтоох

Цагдаагийн байгууллага

Эрүүгийн хууль

Эрүүгийн хэрэг хянан
шийдвэрлэх тухай хууль

ХХГХ-тэй тэмцэх тухай хууль

Иргэний нийгмийн байгууллага

Эрүүгийн хууль

ХХГХ-ийн хохирогчдод
нийгмийн үйлчилгээ үзүүлэх
үдирдамж

Палермогийн протокол

Олон улсын байгууллага

Хохирогчийг тогтоох маягт

Палермогийн протокол

Хохирогч өөрөө хандсан ТОХИОЛДОЛД



Хүүхдээ яаралтай олох



Шүүхээр хохирол
нөхөн гаргуулах




Эх орондоо яаралтай
авчрах



Хамгаалах байр




Санхүүгийн бодит
тусламж хүсэх




Эрүүл мэндийн
үйлчилгээ



Хуулийн байгууллагаар
асуудлыг шийдүүлэх



**Хохирогчийн ар
гэрийнхэн
хандсан
тохиолдолд**



Цагдаа, хууль хяналтын байгууллагын ажилтнууд хандуулах



ХХГХ-ийн хохирогч ТББ-аар дамжин хуулийн байгууллагаар асуудлаа шийдвэрлүүлэх процесс




ХХГХ-ийн хохилогчид үзүүлж буй үйлчилгээ



ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА



ХХГХ-ийн хохирогчдод үйлчилгээ үзүүлж буй ТББ-ын үйлчилгээний зураглал



ХХГХ-ийн хохилогчийн хүсэлтүүд:




ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх үйлчилгээний хийдэл

	Тусгайлан баталсан дүрэм, журамтай эсэх	Төрийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээ	ТББ-аас үзүүлж буй үйлчилгээ	2020 онд төрөөс санхүүжилт олгосон эсэх
Аюулгүй байдлын хамгаалалт	✓		✓	✓
Эрүүл мэндийн үйлчилгээ	✓	✓	✓	
Өмгөөлөл			✓	✓
Сэтгэлзүйн зөвлөгөө, засал			✓	
Мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд зүүчлэх	✓		✓	✓
Нөхөн сэргээх үйлчилгээ			✓	
Хохирогчийн хилийн чанадаас эгүүлэн авчрах	✓	✓	✓	✓

ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх үйлчилгээний зураглал

Судалгааны үр дүнд үндэслэсэн “ХОХИРОГЧ ТӨВТЭЙ ХАНДЛАГА” төлөвшүүлэх санал



Үйлчилгээний хийдлийг арилгаж, үе шат бүрийг тодорхой болгох

- Хуулийн дагуу хохирогчдод үйлчилгээ үзүүлэгч салбар тус бүрээр үйл ажиллагааны нарийвчилсан удирдамж, боловсруулж, хэрэгжүүлэх
- Хэрэгжилтэд хяналт тавих
- Харилцан мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх

Үйлчилгээг санхүүжүүлэх

- Хохирогч илэрсэн цагаас хэвийн амьдралдаа орох хүртэл үйлчилгээний зардлыг жил бүр тооцож, төсөвт суулган санхүүжүүлэх
- ТББ-ын оролцоог нэмэгдүүлэх, гэрээлэн гүйцэтгүүлэх
- Гүйцэтгэлд хяналт тавих

ОУ-ын туршлага

БНСУ, АНУ нь тасралтгүйгээр 1-р ангилалд орж байгаа бөгөөд Филиппин улс 2015 оноос эхлэн тасралтгүйгээр мөн энэ ангилалд шилжиж орсон байна.

Монгол Улс 2006 оноос 2-р ангилалд 14 жилийн турш орж байна.

2017 онд шинэчилсэн Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ЭХ-ийн 124-р зүйлээр шалгагдаж байсан 26 хэрэг хэрэгсэхгүй болсон тул 2018 онд анхаарал татаж буй орны жагсаалтад орж байсан.



ДҮГНЭЛТ

- **Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээний тогтолцоо бүрдээгүй байна.** Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг даган гарсан хохирогчдод үзүүлэх үйлчилгээний журмууд бүрэн гаргаагүй байхын зэрэгцээ хэрэгжилт туйлын сул байна. Хохирогчид хуульд тусгагдсан үйлчилгээг өнөөг хүртэл бүрэн авч чадахгүй зөвхөн төрийн бус байгууллагаас үзүүлж буй үйлчилгээнд хамрагдаж байна. Өөрөөр хэлбэл төрийн байгууллагаас хохирогчид руу чиглэсэн нийгмийн ажил үйлчилгээ болон нөхөн сэргээх, эргэн нийгэмшүүлэх үйлчилгээ байхгүй байна.
- **Төрийн болон төрийн бус байгууллагын аль алинд нь хохирогчийг илрүүлэх, тогтоох, тодорхойлох нэгдсэн аргачлал, удирдамж байхгүй.** Одоогоор үндэсний хэмжээнд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таниж мэдэх, илрүүлэх, тогтоох нэгдсэн, хүлээн зөвшөөрөгдсөн удирдамжийг боловсруулах, батлуулах хэрэгцээтэй байна.
- **Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлсэн туслалцаа, үйлчилгээний талаар нэгдсэн мэдээлэл, судалгаа байхгүй байна.** Өнөөг хүртэл төрийн ба төрийн бус байгууллагын хохирогчид туслалцаа, үйлчилгээ үзүүлсэн талаарх тоо мэдээ нь зөрүүтэй байгаа бөгөөд ТББ -ууд нь илүү олон үйлчлүүлэгчдэд үйлчилгээ үзүүлсэн байна.
- **Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нарт урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ хэрэгцээтэй байна.** Хохирогчдод үзүүлж байгаа үйлчилгээ нь дийлэнх тохиолдолд анхан шатны хэрэгцээнд суурилсан үйлчилгээгээр хязгаарлагдаж байгаа бөгөөд энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хохирогчийг эргэн хэвийн амьдралд нь ороход удаан хугацааны, тогтвортой үйлчилгээ хэрэгтэй байдаг. Нөгөө талаас нэг үйлчлүүлэгчдэд ногдох үйлчилгээний зардал өндөр учир удаан хугацаанд үйлчилгээнд хамруулахад ТББ-уудад хүндрэлтэй байдаг.

-
- **Төрөөс хохирогчийн үйлчилгээнд зориулсан тогтмол төсөв, санхүүжилт хангалтгүй байна.** Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлж буй үйлчилгээ нь өнөөг хүртэл олон улсын донор байгууллагын тусламж, дэмжлэгээр хэрэгжиж байна. Цаашид төрөөс хохирогч хамгаалал, ялангуяа үйлчилгээнд тусгайлсан төсөв хуваарилах, батлуулах шаардлагатай байна.
 - **Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчзөвхөн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй байгууллагын үйлчилгээнд хамрагдаж байна.** Хохирогч амьдарч буй орон нутагтаа шууд туслалцаа, үйлчилгээнд хамрагдах нь хязгаарлагдмал байна. Өөрөөр хэлбэл орон нутгуудад энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлдэг мэргэшсэн байгууллага одоогоор байхгүй.
 - **Эрсдэл өндөртэй гэрч, хохирогчийн аюулгүй байдлын хамгаалах тусгайлсан байр байхгүй.** Эрсдэлийн өндөр түвшинд байгаа гэрч, хохирогчийг байрлуулах тусгай хамгаалах байр байхгүй учир эрсдэлийн түвшингээр үнэлж, хамгаалан байрлуулах боломжгүй байна.
 - **Хохирогчийн хувийн мэдээллийн нууцлалыг ханган ажиллахгүй байна.** Үйлчилгээ үзүүлэх явцдаа төрийн болон төрийн бус байгууллагууд хувь хүний нууцыг хамгаалж, хохирогч, түүний гэр бүлийг дахин эрсдэлд өртөхгүй байх нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй юм.

- **Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн насанд хүрээгүй хохирогчид онцгойлон анхаарал хандуулан ажиллах, үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ байна.** Хохирогч хүүхэд нь насанд хүрсэн хохирогчоос бие махбодь, сэтгэлзүйн хувьд бүрэн хөгжөөгүй, шийдвэр гаргах чадваргүй, насанд хүрэгчдээс хараат зэргээс шалтгаалан түүнд үзүүлэх үйлчилгээ нь ялгаатай гэдгийн хүлээн зөвшөөрч ажиллах, тусгайлан үйлчилгээг үзүүлэх хэрэгтэй байдаг.
- **Үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажиллаж буй мэргэжилтнүүдийг тогтвортойгоор сургах, чадавхжуулах хэрэгцээтэй байна.** Үйлчилгээ үзүүлж буй төрийн болон төрийн бус байгууллагын мэргэжилтнүүдийг хохирогч төвтэй хандлага, аргачлалд тогтмол сургах, мэргэшүүлэх ажлыг тогтвортойгоор дээрх байгууллагууд хамтран хэрэгжүүлэх нь чухал байна.
- **Хохирогч эрсдэлд өртсөн тохиолдолд шуурхай тусламж, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэхэд анхаарлаа хандуулах хэрэгтэй байна.** Хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй тулгарсан тохиолдолд хохирогч хаана, хэнд хандаж үйлчилгээ авах талаарх сурталчилгааг мэдээллийн хэрэгслээр дамжуулан (цахим болон нийгмийн сүлжээ, зөвлөгөө өгөх утас, телевиз, радио, тараах материал гэх мэт) олон нийт, зорилтот бүлэгт ойлгомжтой, хялбаршуулсан байдлаар мэдээллийг тогтвортой хүргэх хэрэгтэй байна.
- **Хохирогч хамгааллын чиглэлээр бусад улсын сайн туршлагыг турших, нэвтрүүлэх чухал байна.** Тухайлбал, Засгийн газраас нөхөн олговор олгодог Филиппин, АНУ зэрэг улсын сайн туршлагыг судлах, мөн АНУ-ын хүүхдийн бэлгийн мөлжлөг, цахим гэмт хэрэгтэй тэмцэх “Хүүхдийн ухаалаг хөтөлбөр” өөрийн орны онцлогт тохируулан хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх гэх мэт.

Санал, ЗӨВЛӨМЖ

Хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох сайжруулах чиглэлээр

1. 2012 онд батлагдсан “Хүн худалдаалахтай тэмцэх тухай” хуулийг 2017 онд шинэчлэн батлагдсан хууль тогтоомжтой нийцүүлэх, сайжруулах, боловсронгуй болгох
2. Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэг ялангуяа ХХГХ-тэй тэмцэхийн тулд гадаад улс оронтой эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг байгуулах, сайжруулах
3. ХХГХ-ийн хэргийг мөрдөн шалгах, хянах, шийдвэрлэх хугацааг богиносгох, хохирогчид дахин түвэг, чирэгдэл үүсгэхээс хамгаалах, урьдчилан сэргийлэх
4. Байгууллага тус бүр алба хаагчдад зориулсан сургалтын төлөвлөгөөндөө ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах талаар тусгах,

Хохирогч хамгаалал чиглэлээр

1. ХХГХ-ийн хохирогчийг илрүүлэх, мөрдөн шалгах, нотлох, гэрч хохирогчийг хамгаалах тусгай тогтсон стандарт арга техник, журам, асуумжийг сайжруулах, боловсруулах, хэрэгжүүлэх
2. ХХГХ-ийн хохирогчийн хамгааллыг сайжруулах, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль (2014), Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012), Эрүүгийн хууль (2017), Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн (2017) нийцлийг хангаж, бодитоор хэрэгжүүлэх
3. “Хохирогчоос мэдүүлэг авах өрөө”-ний ашиглалтыг сайжруулах, зориулалтын дагуу тогтмол ашиглах, үйл ажиллагааны нэгдсэн стандарттай болох
4. Хохирогчийн хохирлыг нөхөн төлүүлэх тусгай сантай болох, учирсан хохирлыг тухайн хэрэг шалгагдаж эхэлсэн цагаас эхлэн барагдуулж байх, гэмт хэрэгтнээс хураасан хөрөнгө, гэмт хэргийн нөхөн төлбөрөөс сандаа төвлөрүүлж ажиллах
5. ХХГХ-ийн хохирогчид туслалцаа үзүүлэх, хүндрэл чирэгдэлгүй төрийн цогц үйлчилгээг бий болгох, хэрэгжүүлэх
6. ХХГХ-ийн хохирогчдод туслалцаа, үйлчилгээ үзүүлдэг мэргэшсэн ТББ-ын үйл ажиллагааг төрөөс дэмжиж ажиллах, хуульд заасны дагуу гэрээгээр зарим чиг үүргийг гүйцэтгүүлж, хохирогчдод зориулсан үйлчилгээг санхүүжүүлж, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, ажиллагсдын аюулгүй байдлын хамгаалалт зэрэгт анхаарлаа хандуулах

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага боловсруулах, сургалт зохион байгуулах чиглэлээр

1. Мэргэшүүлэх гарын авлагыг боловсруулахдаа судалгаанд хамрагдсан алба хаагчдаас гаргасан саналыг тусгах, ялангуяа үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргүүдтэй хамт үйлдэгдэж буй тохиолдлууд, хамаарлыг хэрхэн илрүүлж, мөрдөн шалгах талаар тусгах, Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль (2017), ЭХХШТХ-ийн (2017) ХХГХ-тэй холбоотой зүйлчлэлийн хэрэгжилтээр хэлэлцүүлгийг зохион байгуулах, кейс судалгаа хийх, төсөөтэй хэргүүдийг хэрхэн зүйлчлэх талаар сургалтын гарын авлагад оруулах
2. Гарын авлагыг боловсруулахад хууль сахиулах, шүүгч, прокурор, хил хамгаалах, цагаачлалын алба хаагчдын төлөөллийг оролцуулах
3. Сургалтыг судалгаанд оролцогчдын хүсэж буй ялангуяа “бодит кейс дээр ажиллах”, “багаар ажиллах”, “оролцоонд суурилсан” арга зүй, аргачлалаар зохион байгуулах, мэргэжлийн мэргэшсэн сургагч багш нараар хичээл заалгах.
4. Боловсруулагдан гарсан гарын авлагаар салбар тус бүрт сургалт зохион байгуулах улмаар мэргэшсэн алба хаагчдийг бэлтгэх
5. Сургалтын чанар, үр дүнг хянах шалгуур үзүүлэлт бий болгох, аргачлалыг тодорхойлох

Хамтын ажиллагааны чиглэлээр

1. ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр бусад орны сайн туршлагаас суралцах, судлах
2. Хилийн чанадад үйлдэгдсэн гэмт хэргийн нотлох баримтыг бэхжүүлэх, цуглуулах үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах
3. Гадаад улс орны туршлагыг судлах, сайн туршлагыг нэвтрүүлэх, түүнчлэн алба хаагчдыг мэргэшүүлэн сургах чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх